



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 278

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 268 дугаар тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 11 дугаар сарын 28-ний өдрийн 268 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаанд зайны хяналт тавих журам”-ын/цаашид журам гэх/ 2 дугаар зүйлийн 2.2, 2.5, 2.6, 2.7, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгүүдийг дараах байдлаар тус тус өөрчилсүгэй.

1/2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг:

2.2.“... ТУЗ нь Хорооны 2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 78 дугаар тогтоолоор баталсан ХК-ийн хурлын зар мэдээг хүргэх, санал авах журамд заасны дагуу ...” гэснийг “...Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам ...” гэж, мөн хэсгийн “... Компанийн тухай хуулийн 61.2-т ...” гэснийг “... Компанийн тухай хуулийн 60.2-т...” гэж;

2/2 дугаар зүйлийн 2.5 дахь хэсэг:

2.5. дахь хэсгийн “... Компанийн тухай хуулийн 60.3-т заасны дагуу компанийн ТУЗ-ийн болон ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болсон тухай болон хурал зарлан хуралдуулах эрх нь хувьцаа эзэмшигч бүрт нээлттэй болсон тухай нийтэд зарлаж, харилцагч банкинд мэдээлнэ ...” гэснийг “... Компанийн тухай хуулийн 59.7-д заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээлнэ ...” гэж;

3/2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг:

2.6. дахь хэсгийн “...Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.1.5-д зааснаар хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын шийдвэр, тэмдэглэлийг 6 дугаар сарын 1-ний дотор, ээлжит

000317

бус хурлынхыг хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор Хороонд ирүүлж байх ёстой...” гэснийг “... Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8-д хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх...” гэж;

4/2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг:

2.7. дахь хэсгийн “... Компанийн тухай хуулийн 64.7-д хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэж болохгүй гэж заасан. Иймд хурлаар хэлэлцэхээр товлоогүй асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан бол уг шийдвэрийг хүчингүй гэж үзэх үндэслэл болно...” гэснийг “...Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүйбөгөөдшаардлагатай гэж үзвэл Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг компанийн дүрэмд зааж болно ...” гэж;

5/3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг:

3.1 дахь хэсгийн “... Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.1.3-т заасны дагуу ХК нь хагас жилийн болон аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд гаргаж, Хороонд ирүүлэх үүрэгтэй...” гэснийг “... Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6.-д зааснаар хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй ...” гэж;

2. Журмын 4 дүгээр зүйлийн 4.12 дахь хэсгийн“.../Компанийн засаглалын кодексийн 4.2.3-т зааснаар тодорхойлно/...”гэснийг хассугай.

3. Журмын 5 дугаар бүлгийг хүчингүй болгосугай.

4. Журамд нэмэлт өөрчлөлтийг оруулж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-ддаалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН